



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/199

Чингис хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь хэсэг, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Жагсаалт батлах, эрх шилжүүлэх тухай” 2018 оны А/230 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/230 дугаар тушаалаар батлагдсан “Сургуулийн барилгын засвар /Хэнтий, Баян-Овоо сум/” барилгын их засварын ажлын худалдан авах ажиллагааны захиалагчийн эрхийг Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлсүгэй.

2. Тус ажлын худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт өртөгт багтаан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, тайлагнахыг Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын даргад үүрэг болгосугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА